



БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жавхан Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.03.21 № 12

Боловсролын бодлого, үйл
ажиллагаанд тэгш хүртээмжтэй,
ялгаварлан гадуурхахгүй байх
зарчмыг хэрэгжүүлэх талаар асуулга
хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх”, Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх” зарчмыг тунхагласан боловч боловсролын салбарын бодлого үйл ажиллагаанд энэ зарчим хэрэгжихгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд дараах хоёр чиглэлээр асуулга тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 4000-5100 төгрөг байхаар тооцож, үүний 1000 төгрөгийг тухайн хүүхдийн эцэг, эхээр төлүүлж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын төрийн болон хувийн сургуулийн сурагчийн үдийн хоолны зардлыг 2500-3400 төгрөгөөр тооцон төрөөс олгож байна. Харин хувийн цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа 30,260 хүүхдийн хоолны зардлыг эцэг, эх нь бүрэн хариуцаж байна. Иймд хувийн, төрийн цэцэрлэг гэж ялгаварлахгүйгээр цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг адил тэгш олгох талаар Боловсролын яамны зүгээс ямар арга хэмжээ авч байгаа талаар;


2. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасны дагуу зөвхөн төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургуулийн багш болон ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 36 сарын шалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж авах, нэг хүүхэд нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцах боломжийг төрөөс олгож байна. Харин төрийн өмчийн их, дээд сургуулийн багш, түүнчлэн хувийн хэвшлийн бүх шатны боловсролын байгууллагын багш нар багшийн нийгмийн баталгааг хангах төрийн энэ бодлогын гадна үлдээд байна.

2025000019

Иймд боловсролын салбарт ажиллаж байгаа нийт багш, ажилтны нийгмийн баталгааг хангах, хөгжлийг дэмжих талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар, тэр тусмаа төрийн өмчийн их дээд сургуульд ажиллаж байгаа багшийн нийгмийн баталгааг хангах талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуулга тавьж байна.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд багтааж ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн;

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  *B. Хэрлэн* Б.ХЭРЛЭН